




ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН ЁС ЗҮЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг зүйлс

1.1. "ҮБХИС-ийн ёс зүйн дүрэм" /цаашид Ёс зүйн дүрэм гэх/-ийн зорилго нь тус сургуульд суралцагч болон ажиллагсдын дагаж мөрдвөл зохих зан төлөв, ёс суртахууны нийтлэг хэм хэмжээг тогтоон хэвшүүлэхэд оршино.

1.2. Ёс зүйн дүрмийн үйлчлэл нь ҮБХИС-ийн суралцагч, ажиллагсад болон гэрээний үндсэн дээр түр ажиллаж байгаа зөвлөх, бүтэн бус цагийн багш, албан хаагчид, түр хугацааны сургалт дамжаанд хамрагдаж байгаа суралцагчдад адил хамаарна.

Хоёр. ҮБХИС-ийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээ

2.1. ҮБХИС-д ажиллагсдын эрхэмлэх үнэт зүйлс нь:

2.1.1. Шударга ёсны зарчмын хүрээнд хүлээсэн үүрэгтээ үнэнч байж, нийтийн ашиг сонирхолд захирагдан, ашиг сонирхлын зөрчилд автахгүй байх, хууль бус, шударга бус явдалтай эвлэршгүй байж, бусдыг манлайлах;

2.1.2. Хууль дээдлэх зарчмын хүрээнд үйл ажиллагаандаа төрийн бодлого, шийдвэр болон Үндсэн хууль, бусад хуулийг ямагт дээдлэн сахих;

2.1.3. Тэгш байдлын зарчмын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч болон үйлчлүүлэгч, иргэн бүртэй адил тэгш, алагчлалгүй харьцан байгууллагын хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах;

2.1.4. Хариуцлага хүлээх зарчмын хүрээнд албан үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн мэдлэг чадварыг байнга дээшлүүлж, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнгийн төлөө бүрэн хариуцлага хүлээх;

2.1.5. Олон нийтэд үйлчлэх зарчмын хүрээнд төрийн үйлчилгээг олон нийтэд чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэж, тэдний итгэлийг хүлээж ажиллах.

2.2. ҮБХИС-ийн нийт ажиллагсад дээрх эрхэмлэх үнэт зүйлсийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаандаа дараах нийтлэг ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

2.2.1. Хөдөлмөрийн хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ажлын цагийг бүрэн, үр бүтээлтэй ашиглах;

2.2.2. Үндсэн ажлаасаа гадуур хуулиар зөвшөөрснөөс бусад ажил үүрэг эрхлэхгүй байх;

2.2.3. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орон, ард түмнийхээ эрх ашгийг хувийн ашиг сонирхлоос ямагт дээгүүр тавьж, өөрт олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа нөхцөл байдлаас татгалзах;

2.2.4. Албан үүргээ гүйцэтгэсэн болон гүйцэтгээгүйн улмаас ашиг сонирхол нь хөндөгдөх дотоод, гадаадын аливаа иргэн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, тэдэнтэй үгсэн тохирох, амлалт өгөх, тэднээс шан харамж, хөнгөлөлттэй үйлчилгээ, зээл авах, хууль бус бусад хангамж эдлэхгүй байх;

2.2.5. Үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод хэм хэмжээг чанд баримтлах;

2.2.6. Удирдах албан тушаалтныг асуудал шийдвэрлэх, шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангах;

2.2.7. Хууль зөрчсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэлтэй эвлэршгүй байж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдээлэх;

2.2.8. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байж, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглах, албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тараахгүй байх;

2.2.9. Төрийн байгууллагын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг албаны бус зорилгоор ашиглахгүй байх;

2.2.10. Албан тушаалын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгч, хамтран ажиллагсадтайгаа эелдэг, адил тэгш, хүлээцтэй, хүндэтгэлтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаварлалгүйгээр хөнгөн шуурхай хүргэх;

2.2.11. Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн болон хүйсийн хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, хөгжлийн бэрхшээл, гадаад төрхөөр нь ялгаварлан гадуурхахгүй байх;

2.2.12. Танил тал, найз нөхөд, гэр бүл, төрөл садны хүмүүс ажиллаж байгаа байгууллага, тэдний ашиг сонирхолтой холбоотой асуудлаар шийдвэр гаргах, албаны нэр барих зэргээр албан тушаал, эрх мэдлээ хууль бусаар ашиглахыг цээрлэх;

2.2.13. Албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглах, бусдыг дарамтлах, хавчин гадуурхах, хүйсээр нь ялгаварлах, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтад оруулах, эрхшээлдээ байлгахгүй байх;

2.2.14. Бусад албан хаагчийн үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх, саад болох, хууль бус үйлдэл хийхийг шаардах, үүрэг даалгавар өгөхгүй байх;

2.2.15. Өөрийн мэдлэг чадвар, дадал туршлагаа байнга хөгжүүлж, төрийн албаны нэр хүндийг ямагт дээдлэх;

2.2.16. Албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг биечлэн хангах;

2.2.17. Удирдлагын санаа бодолд нийцэх эсэхийг үл харгалзан тэдний гаргах шийдвэрээс үүдэн гарч болзошгүй үр дагавар, сөрөг талыг урьдчилан анхааруулж байх;

2.2.18. Захирах, захирагдах ёсны зарчмыг баримталж, тодорхой асуудлаар өөр саналтай байсан ч удирдлагаас гаргасан хуульд нийцсэн шийдвэр, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх;

2.2.19. Албан үүргээ гүйцэтгэж байхдаа буюу ажлын байрандаа согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, этгээд байдлаар хувцаслах, бүдүүлэг зан авир гаргахыг цээрлэх;

2.2.20. Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулах, албан тушаал өөрчлөгдөх, халагдах үедээ мэдээллийн санг устгах, өөрчлөх, ажил үүргийн

хувьд хамааралтай мэдээлэл, тайлан, судалгааг эрх бүхий албан тушаалтанд өгөхөөс татгалзахгүй байх;

2.2.21. Байгууллагынхаа зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх талаар төрийн байгууллагаас явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн мэдээ, мэдээлэл тараахгүй байх;

2.2.22. Албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг дээдлэн хүндэтгэх;

2.2.23. Төрийн алба, байгууллагын соёл, дэг журмыг баримтлан иргэдтэй төлөв төвшин харилцах;

2.2.24. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг зохих дүрэм, журмын дагуу цаг алдалгүй, ил тод, түргэн шуурхай хүргэх;

2.2.25. Мөрийтэй болон бооцоот тоглоом тоглохгүй байх;

2.2.26. Улс төрийн намын харьяаллаас ангид байж, аливаа шашны үйл ажиллагааг сурталчлахгүй байх.

Гурав. ҮБХИС-ийн багш, судлаачийн ёс зүйн хэм хэмжээ

3.1. Хүний эрх, эрх чөлөө, мэргэжлийн үнэ цэнэ, эрхэмсэг оршихуйг хүндэтгэх, үнэнийг эрэлхийлэх, эрдэм мэдлэгийг дээдлэх, шударга, зарчимч байдал, ёс журмыг сахин биелүүлэх нь багшийн эрхэмлэх үнэт зүйл мөн.

3.2. Багш, судлаач нь сургалтын үйл ажиллагаанд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

3.2.1. Маргалдах, мэтгэлцэх, егөөдөх, таамаглал дэвшүүлэх, үгүйсгэн няцаах зэрэг сэтгэлгээний зүй ёсны аргуудыг хэрэглэж болох боловч бусдыг дутуу үнэлэн, басамжлан доромжлох байдал гаргахгүй байх;

3.2.2. Суралцагчийг хүмүүжүүлэх, төлөвшүүлэх, сахилга, хариуцлагатай байх зан үйлд сургах багшийн мэргэжлийн үүрэгт сөрөг байдлаар нөлөөлөхгүй байх;

3.2.3. Сургалтын хөтөлбөр, түүний дагуу эзэмшүүлэх ёстой цогц мэдлэг, ур чадварын хүрээнд хичээл сургалт явуулах, эрдэм шинжилгээний ажил эрхлэх, бүтээл туурвил гаргахдаа багш бүр өөрийн хамгийн зөв гэж үзсэн шийдлийг дэвшүүлэн тавих эрхийг энэхүү дүрмээр хязгаарлахгүй байх;

3.2.4. Багш нь хуваарьт цагийн хичээлийг таслах, хоцрох, эрт тараах, хичээлийн цагаар танхимыг дур мэдэн орхихгүй байх;

3.2.5. Суралцагчийн сурлагын үнэлгээг бодитой бус, шударга бусаар үнэлэхгүй байх;

3.2.6. Зохих журмаар батлагдсан хичээлийн хөтөлбөр, бусдын судалгааны чиглэлийг үгүйсгэж, тэдгээрт итгэх суралцагчийн итгэлийг хөсөрдүүлэхгүй байх;

3.2.7. Суралцагсад бие даан сурах хэрэглэгдэхүүн, хичээлийн гарын авлага, ном сурах бичиг тулган борлуулахгүй байх;

3.2.8. Суралцагчид дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

3.2.9. Суралцагчийн сурлагад ахиц гарахад саад болох үйлдэл, эс үйлдэл гаргахыг цээрлэх;

3.2.10. Бусдын бүтээлийг өөрийн болгож илэрхийлэхгүй байх;

3.2.11. Судалгаанд хамтарч оролцсон эрдэм шинжилгээний ажилтан, багш, суралцагсад, туслах ажилтны эрх, ашиг сонирхол, нэр төрийг сэвтээх, оролцооны хувь нэмрийг шударга бус үнэлэхгүй байх;

3.2.12. Судалгааны үр дүнг дөвийлгөх, үнэн байдлыг гуйвуулах, зохиомлоор тайлагнахгүй байх;

3.2.13. Сургалт, судалгааны ажлын хүрээнд улс төржих, хувийн ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх;

3.2.14. Бусдын ажил, судалгаа, шинжилгээний бүтээлийг дүгнэхдээ мэргэжлийн бус шалгуураар хандах, мэргэжлийн ур чадварыг нь буруу илэрхийлэх, дутуу үнэлэхгүй байх;

3.2.15. Бусдын ажил, судалгаа, шинжилгээний бүтээлийг дүгнэхдээ мэргэжлийн бус шалгуураар хандах, мэргэжлийн ур чадварыг нь буруу илэрхийлэх, дутуу үнэлэхгүй байх;

3.2.16. Бусад судлаачийн үзэл баримтлалыг хүндэтгэх, ойлгох, мөн өөрийн үзэл баримтлалыг бусдад зөв ойлгуулахдаа байгууллага, хувь хүний нэр төрд халдах, гүтгэх, доромжлохгүй байх;

3.2.17. Судалгааны ажилдаа үнэнч, чин сэтгэлээсээ хандаж, судалгаа, шинжилгээний зориулалттай нийтийн эзэмшлийн техник, тоног төхөөрөмжийг зөвхөн зориулалтын дагуу ашиглах;

3.2.18. Судалгааны ололт, үр дүнг хүн, нийгмийн эсрэг болон хувийн явцуу зорилгод урвуулан ашиглахгүй байх.

3.3. Багш нь суралцагчтай харилцах харилцаанд дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө.

3.3.1. Суралцагчийн язгуур эрх ашгийг дээдэлж, танин мэдэх чөлөөт эрмэлзлийг дэмжин хөгжүүлж, хүндэтгэлтэй, тэгш, шударга, бодитой хандах, харилцан итгэл хүлээж харилцах;

3.3.2. Суралцагч санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх уур амьсгал бүрдүүлэх;

3.3.3. Суралцагчийн суралцах идэвх санаачилгыг өрнүүлж, оюуны эрэл хайгуулд хамтдаа зүтгэгч хэмээн хүндэтгэж харьцах;

3.3.4. Суралцагчийг зөв хүмүүжилтэй, харилцааны соёлтой иргэн болж төлөвшихөд нь туслах, биеэр үлгэрлэх;

3.3.5. Хувийн ашиг сонирхолд нийцүүлэн суралцагчийн хөдөлмөрийг ашиглахгүй байх;

3.3.6. Мэргэжлийн эсвэл хуулийн зайлшгүй шаардлага бий болсноос бусад тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагааны явцад олж авсан суралцагчийн талаарх мэдээллийг бусдад задруулахгүй байх;

3.3.7. Суралцагчийг хүйсээр болон бусад байдлаар ялгаварласан, ичээх, зовоох, гутаах, доромжлох үг хэлэх, тэгш бус хандах;

3.3.8. Суралцагчид бэлгийн дарамт үзүүлэхгүй байх;

3.3.9. Өөрийн давуу байдлыг ашиглан суралцагчид аливаа бусад дарамт, шахалт үзүүлэхгүй байх;

3.3.10. Багаар ажиллахдаа үзэл бодлын зөрүү, гүйцэтгэж буй ажилд үл хамаарах маргаан, санал үл нийцэх үр дагаврыг өдөөх байр сууринаас хандахгүй байх.

Дөрөв. ҮБХИС-д суралцагчийн ёс зүйн хэм хэмжээ

4.1. ҮБХИС-ийн эрхэм зорилго, зорилт, суралцагчдын уриаг дээдлэн, сургуулийнхаа нэр хүндийг өндөрт өргөн, сурах үйлсэд өөрийн хүч оюуныг бүрэн дайчлан, сонгосон мэргэжилдээ шамдан суралцаж, эх орон, Зэвсэгт хүчнийхээ хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах шилдэг, чадварлаг боловсон хүчин болохыг тэмүүлэх нь ҮБХИС-д суралцагчдын эрхэмлэх үнэт зүйлс мөн.

4.2. Суралцагчид дараах ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө. Үүнд:

4.2.1. Цэргийн сургуулийн суралцагчийн онцлог болох ёсолж хүндэтгэх ажиллагаа, жагсаалч байдлыг хэрэгжүүлэн сахидаг байх;

4.2.2. Цэргийн болон оюутны дүрэмт хувцсыг хэрэглэх ба хувцас өмсөх зааврыг зөрчих, өнгө үзэмж алдсан хувцас өмсөж, ард иргэдийн дунд сургууль, өөрийн болон хамт олныхоо нэр хүндийг гутаах, сонсогч, оюутан бүрийн биедээ авч явах хувийн бичиг баримтаа шалгуулахаас зайлсхийх, сургуулийн орчинд бичиг баримтгүйгээр нэвтрэхгүй байх;

4.2.3. Сургуулийн орчинд болон олон нийтийн газар цэргийн болон оюутны дүрэмт хувцастайгаар архи, согтууруулах ундааны зүйлс, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэх, тусгайлан зөвшөөрснөөс бусад орчинд тамхи татах, олон нийтийн дунд бүдүүлэг үг хэллэг хэрэглэх зэргээр хувийн соёлгүй үйлдэл гаргах, биеэ зүй бус авч явахгүй байх;

4.2.4. Хичээл сургууль, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны бүтээл, ангийн болон график тооцооны ажил, дипломын ажил зэргийг бичих явцад бусдын оюуны бүтээл, нээлтийн ололтыг зөвшөөрөлгүй ашиглах, хууль бусаар өөрийн болгох зэрэг зохисгүй үйлдэл гаргахгүй, оюун санааны цэвэр ариун байх тогтсон дэгийг зөрчихгүй байх;

4.2.5. Бусдын эрх чөлөөнд бүдүүлгээр халдах, айлган сүрдүүлэх, дарамтлах, хамт суйралцагсдынхаа сурч боловсрох эрхэд санаатайгаар саад учруулахгүй байх;

4.2.6. Хичээл таслах, хожимдох, сурлагын дүнгээ өөрчилж, журнал болон сурлагын дэвтрийг засах, багшийн гарын үсгийг хуурамчаар дуурайн үйлдэх, сургалтын явцын болон төгсөлтийн шалгалт, улсын шалгалтын журмыг зөрчихгүй байх;

4.2.7. Сургалтын материаллаг бааз, хичээлийн болон цэргийн байрны эд хогшлыг ариг гамгүй хэрэглэх, санаатай эвдэх, өнгө үзэмж чанарыг алдагдуулахгүй байх;

4.2.8. Ёс суртахууны ноцтой зөрчил гарсан болон хэн гаргасныг мэдэж байсан боловч зүй бус явдалтай эвлэрсэн, санаатайгаар нуун далдалсан үйлдэл хийхгүй байх;

4.2.9. Сургуулийн удирдлага, эрдэмтэн багш, ажиллагсад, захирагч дарга нараа хүндэтгэн харьцах;

4.2.10. Хамтран суралцаж буй суралцагсдадаа аливаа байдлаар саад хийхгүй, оюуны эрэл хайгуулд хамтдаа зүтгэгч нөхөр хэмээн тусалж дэмжин, хүнлэг энэрэнгүй, нөхөрсөг, нийтэч харьцах;

4.2.11. Багш, шавийн барилдлагыг хүндэтгэн дээдлэх;

4.2.12. ҮБХИС-ийн нийт суралцагчид нь дээрх үндсэн зарчмуудаас гадна нийгмийн ёс зүйн түгээмэл хэм хэмжээ, өөрийн суралцаж буй мэргэжлийн ёс зүйн тусгай зарчмуудыг сахина.

Тав. "Ёс зүйн дэд хороон"-ны бүрэлдэхүүнийг томилох, тавигдах шаардлага

5.1. Их сургуулийн "Ёс зүйн дэд хороо" нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу байгууллагын нийт албан хаагчдын санал хураалтаас олонхын дэмжлэг авсан, сондгой тооны гишүүнтэй байна.

5.2. "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүдийг сонгох үйл ажиллагааг Захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгж зохион байгуулна.

5.3. Их сургуулийн "Ёс зүйн дэд хороо" нь 7 гишүүнтэй байна.

5.4. "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүдийн олонхын саналаар даргаа сонгоно.

5.5. "Ёс зүйн дэд хороо"-ны нарийн бичгийн даргын чиг үүргийг гишүүд ээлжилж хэрэгжүүлэх ба хугацааг "Ёс зүйн дэд хороо" батална.

5.6. "Ёс зүйн дэд хороо"-ны бүрэлдэхүүнийг их сургуулийн захирлын тушаалаар баталгаажуулна.

5.7. "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх тухайгаа бичгээр гаргасан, Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 47 дугаар зүйлийн 47.1-д заасны дагуу орон гарвал Захиргааны асуудал хариуцсан нэгж нөхөн сонгох арга хэмжээг ажлын 7 хоногийн дотор зохион байгуулна. Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

5.8. "Ёс зүйн дэд хороо"-ны даргын эзгүйд түүний үүргийг даргын эрх олгосноор дэд хорооны аль нэг гишүүн гүйцэтгэнэ.

5.9. "Ёс зүйн дэд хороо"-ны гишүүн нь гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлд байгаагүй, сахилгын болон ёс зүйн шийтгэл хүлээгээгүй, шударга, хамт олондоо хүлээн зөвшөөрөгдсөн албан хаагч байна.

Зургаа. Ёс зүйн зөрчлийн тухай ойлголт, түүнийг хянан шалгах, шийдвэрлэх

6.1. Ёс зүйн зөрчил гэдэгт ёс зүйн үндсэн зарчмууд, нийгмийн зан суртахууны түгээмэл хэм хэмжээнд харшилсан, шууд болон шууд бус байдлаар хохирол учруулсан, энэхүү дүрэмд заасан хэм хэмжээг зөрчсөн ёс зүйн сөрөг үнэлэмж бүхий үйлдэл болон эс үйлдэхүйг ойлгоно. Ёс зүйн зөрчлийг дараах үндэслэлээр хянан шалгана. Үүнд:

6.1.1. Байгууллага, иргэдээс гаргасан өргөдөл, гомдол, санал, мэдээлэл,

6.1.2. Дотоодын хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал,

6.1.3. Шаардлагатай гэж үзвэл удирдлагын санаачилгаар,

6.1.4. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэгдсэн мэдээ мэдээлэлд.

6.1.5. Ёс зүйн зөвлөл, хороонд илгээх аливаа хүсэлт нь дараах бүрдүүлбэртэй байвал зохино. Үүнд:

6.1.6. Хэлэлцэхийг хүссэн асуудлын тухай тодорхойлолт /өргөдөл/

6.1.7. Холбогдох баримт нотолгооны хураангуй ба аливаа холбогдох баримтуудын хуулбарууд.

6.2. Энэхүү ёс зүйн дүрмийг зөрчсөн байж болох талаар ажилтан болон бусад оролцогчид нь аливаа асуудлыг эхлээд шууд их сургуулийн "Ёс зүйн дэд хороо"-нд гаргана.

6.3. Ёс зүйн дэд хорооны чиг үүрэг, бүрэлдэхүүний эрх, үүрэг, баталгаа, гомдол, мэдээлэл хүлээн авч, хянан шалгах, хуралдааны зохион байгуулалт, гомдол, мэдээллийг хянан шалгах, шийдвэрлэх, Тайлан мэдээтэй холбоотой харилцааг Ёс зүйн хорооны 2024 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Ёс зүйн дэд хорооны ажиллах журам"-аар зохицуулна.

Долоо. Ёс зүйн хариуцлага ногдуулах

7.1. Ёс зүйн ноцтой зөрчил гаргасан суралцагчдад дараах хариуцлагын арга хэмжээг авна. Үүнд:

7.1.1. Тодорхой хугацаагаар суралцах эрхийг түдгэлзүүлэх;

7.1.2. Сургуулиас хасах.

Тайлбар: Ёс зүйн ноцтой зөрчил гэж ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн үйлдэл эс үйлдэхүйг ойлгоно.

7.2. Энэ дүрэмд заасан ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн албан хаагчид тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн зөрчлийн шинж байдал, анх буюу давтан үйлдсэнийг нь харгалзан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасан ёс зүйн хариуцлага ногдуулна.

7.3. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт заасны дагуу тухайн байгууллагын Ёс зүйн дэд хорооны дүгнэлтээр тухайн цэргийн алба хаагч ёс зүйн зөрчил гаргасан нь тогтоогдсон бол түүнд албан ёсоор мэдэгдсэнээр хариуцлагыг сайн дураараа хүлээх боломж олгоно.

7.4. Албан хаагч нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт заасан ёс зүйн хариуцлагыг сайн дураараа хүлээж болно.

7.5. Энэхүү ёс зүйн дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчсөн тухай хэрэг явдлыг шалган тогтоох явцад тухайн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын зохих байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

Найм. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах

8.1. Ёс зүйн дүрмийг сургуулийн цахим хуудаст байрлуулна.

8.2. Ёс зүйн дүрмийг хөдөлмөрийн гэрээ байгуулж буй ажилтан, албан хаагч, элссэн орж буй оюутан сурагчдад танилцуулна.

8.3. "Ёс зүйн дэд хороо" нь дүрмийн хэрэгжилтийг ханган, тайланг улирал бүр Батлан хамгаалах яамны "Ёс зүйн дэд хороо"-нд тайлагнана.

8.4. Бүрэлдэхүүн сургууль, бүтцийн нэгжийн захирал, дарга нар өөрийн хариуцсан нэгждээ "Ёс зүйн дүрэм"-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, сар бүрийн эхний долоо хоногийн 3 дахь өдрийг ёс зүйн сургалт, сурталчилгааны өдөр болгон арга хэмжээ зохион байгуулж ажиллана.

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬ